



**ТӨВ АЙМГИЙН
ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/292

Зуунмод

┌ Ургацын штаб байгуулах ┐
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дүвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Тариалангийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/612 дугаар захирамжийг тус тус үндэслэн хэрэгжүүлэхээр ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ургац хураалтын ажлыг технологийн хугацаанд явуулах баг, аж ахуйн нэгж, иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэх хүрээнд сумын ургацын штабыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Батжаргал	-Хөдөө аж ахуйн тасгийн дарга
Гишүүдэд:	Д.Амартүвшин	-Хууль эрх зүйн мэргэжилтэн
	Х.Олзод	-Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн
	Ц.Алтанцэцэг	-Нийгмийн бодлогын мэргэжилтэн
	Г.Уянга	-ИХМОНХАжилтан
		-Багийн Засаг дарга, Зохион байгуулагч нар
Нарийн бичгийн дарга:	Д.Өнөрбаяр	-Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн

2. Штабын дарга, нарийн бичгийн дарга (Д.Өнөрбаяр)-т ДААЛГАХ нь:

2.1. Штабын дотоод ажлын төлөвлөгөө, ажил үүргийн хуваарийг хавсралтаар боловсруулан батлуулах, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх

3. Штабын гишүүдэд ДААЛГАХ нь:

3.1. Багууд ургац хураалтын явцын мэдээг 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 7 хоног бүрийн Баасан гарагт 16.00 цагаас өмнө 70273514, 88688125 дугаарын утсанд тогтмол өгөх

3.2. Багуудаас ирүүлсэн явцын мэдээг хянан нэгтгэж 7 хоног бүрийн Даваа, Пүрэв гарагуудад 12 цагаас өмнө аймгийн ургацын штабын 70272581 утсанд тогтмол мэдээлж удирдлагуудыг мэдээ, мэдээллээр хангах

3.3. Газар тариалангийн үйлдвэрлэлд бүртгэлийн нэгдсэн цахим систем нэвтэрч байгаатай холбогдуулан тариалангийн бүртгэлийн систем, хүнсний ногооны урамшууллын журмын хэрэгжилтэд хяналт тавьж, газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийг бүрэн хамруулах

3.2. Ургац хураалтад шаардлагатай байгаа ажиллах хүч хүч, техник, шатахуун тээвэр, агуулах зоорины бэлэн байдлыг хангуулах, дутагдаж байгаа ажиллах хүчний судалгааг 9 сарын 15-ны дотор сумын ургацын штабт саналаа өгч шийдвэрлүүлэх

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Батжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ч.САРАНГЭРЭЛ



Зуунмод Сумын Засаг даргын 2023 оны
09 дүгээр сарын 06, -ны өдрийн
 АХЯД дугаар захирамжийн хавсралт

**УРГАЦЫН ШТАБЫН ДОТООД АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ,
 АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ**

№	Штабын гишүүдийн нэр	Албан тушаал	Хугацаа	Ажил үүргийн хуваарь
1	Д.Өнөрбаяр, штабын гишүүд	ХААТ-ийн мэргэжилтэн	9 сард	Захирамжийн хэрэгжилтийг хангах
2	Ц.Мөнхтуяа, Д.Өнөрбаяр	Нягтлан бодогч	9 сард	Шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх
3	Ц.Мөнхтуяа, Д.Өнөрбаяр	Нягтлан бодогч	9 сард	Ургац хураалтад ажиллах техник, шатахууны асуудал
4	Ц.Алтанцэцэг, Д.Өнөрбаяр	НБМ-ын мэргэжилтэн	9 сард	Ургац хураалтад ажиллах хүн хүчний асуудал
5	Г.Уянга, Д.Өнөрбаяр	ИХМОНХА	9, 10 сард	Цаг үеийн ажлын явцыг олон нийтэд хүргэж сурталчилах
6	Б.Батжаргал	ХААТасгийн дарга	9 сарын 15-ны дотор	Баг, аж ахуйн нэгж, иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэх
7	Д.Өнөрбаяр, Б.Туул, Н.Мөнх-Өнөр, Ш.Цэндсүрэн, Ч.Одончимэг, Р.Баярсайхан, Б.Отгонбаяр, Д.Энхтуул, Ч.Анхзаяа, А.Нарангэрэл, О.Нямсүрэн, Д.Отгонгэрэл,	ХААТ-ийн мэргэжилтэн, Багийн Засаг дарга, Зохион байгуулагч нар	Тухай бүр	Газар тариалангийн үйлдвэрлэлд бүртгэлийн нэгдсэн цахим систем нэвтэрч байгаатай холбогдуулан тариалангийн бүртгэлийн систем, хүнсний ногооны урамшууллын журмын хэрэгжилтэд хяналт тавьж, газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийг бүрэн хамруулах
8	Б.Туул, Н.Мөнх-Өнөр, Ш.Цэндсүрэн, Х.Олзод, Ч.Одончимэг, Р.Баярсайхан, Ч.Анхзаяа, Б.Отгонбаяр, Д.Энхтуул, А.Нарангэрэл, Ч.Анхзаяа, Д.Отгонгэрэл, О.Нямсүрэн	Багийн Засаг дарга, Зохион байгуулагч нар	9 сарын 15-ны дотор	Ургац хураалтад шаардлагатай байгаа ажиллах хүн хүч, техник, шатахуун тээвэр, агуулах зоорины бэлэн байдлыг хангуулах, дутагдаж байгаа ажиллах хүчний судалгааг 9 сарын 15-ны дотор сумын ургацын штабт саналаа өгч шийдвэрлүүлэх
9	Б.Туул, Н.Мөнх-Өнөр, Ш.Цэндсүрэн, Ч.Одончимэг, Р.Баярсайхан, Б.Отгонбаяр, Д.Энхтуул,	Багийн Засаг дарга, Зохион байгуулагч нар	7 хоног бүр	Багууд ургац хураалтын явцын мэдээг 9 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн 7 хоног бүрийн Баасан гарагт 16 цагаас өмнө 70273514

	А.Нарангэрэл, Ч.Анхзаяа, Д.Отгонгэрэл, О.Нямсүрэн			дугаарын утсанд тогтмол өгөх
10	ХААТ-ийн мэргэжилтэн Д.Өнөрбаяр		7 хоног бүр	Багуудаас ирүүлсэн явцын мэдээг хянан нэгтгэж 7 хоног бүрийн Даваа, Пүрэв гарагуудад 12 цагаас өмнө аймгийн ургацын штабын 70272581 утсанд тогтмол мэдээлж удирдлагуудыг мэдээ, мэдээллээр хангах
11	Б.Батжаргал, Д.Өнөрбаяр, Х.Олзод, Б.Сарантуяа, Э.Долгормаа	ХААТасаг	10 сарын 15-ны дотор	Багийн газар тариалан эрхэлдэг өрхүүд болон өрхийн үйлдвэрлэл эрхэлдэг өрхүүдтэй хамтран “Зуунмодод үйлдвэрлэв”, “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдааг 09 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулах

_____оОо_____